



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

2024.03.19

Удирдлага зохион байгуулалт:

Нийтийн Номын сан нь үйл ажиллагаандаа Номын сангийн тухай хууль, Соёлын тухай хууль, Монгол хэлний тухай хууль болон Төрөөс соёлын талаар баримтлах бодлого хөтөлбөр, бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Энэ хугацаанд үйл ажиллагаатай холбоотой “А” тушаал 1, хүний нөөцийн холбогдолтой “Б” тушаал 5, холбогдох хууль эрх зүйн хүрээнд хяналтын дагалдах хуудсыг хавсарган гаргаж албан хэрэг хөтлөлтийн стандарт, дүрэм журмын дагуу байгууллагаас явсан 16, бусад байгууллагаас ирсэн хариутай бичиг 10, ирсэн бичиг 10-г албан хэрэг хөтлөлтийн шатанд баримт бичгийн эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг ханган ажиллаж, хариутай албан бичигт хариуг нь хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

2015-2021 оны байнга хадгалах 115 баримтыг Төрийн архивын нэгдсэн сангийн сайтанд шивэлт хийж хадгаламжийн нэгж үүсгэсэн. Захирлын тушаал “А” 2015-2021 оны 361 хуудас баримтыг нэг бүрчлэн скайнардаж, фото шопын программ дээр янзалж стандартын дагуу болгож Төрийн архивийн нэгдсэн санд шивэлт хийж дуусгасан.

1. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- “Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст” ERP -р 7 хоногт бүр Удирдах ажилтны шуурхай зөвөлгөөний 4 үүргийн биелэлтийг Пүрэв гарагт ERP-р хүргүүлж байна.
- 2024 оны 1 улирлын Статистик мэдээ, Өргөдөл гомдлын тайланг гаргасан.

Уншлага үйлчилгээний ажлын хүрээнд:

Ном уншлагын 2 сарын аянг зохион байгуулан ажиллаж байна. Нийт 625 уншигчдад 2890 ном хэвлэл олгож үйлчилсэн. Үүнээс

- Уншлагын танхимаар 562 уншигчидад 2785 ширхэг ном
- Гэрээр ном олгох үйлчилгээг 54 уншигчдад 87 ширхэг ном
- Зөөврөөр номын үйлчилгээг 4 байгууллагын 9 уншигчдад 18 ширхэг ном

Татгалзалд 5 ширхэг ном бүртгэгдсэн.

Уншлагын танхимаар шинэ болон сунгалтын карт 596 уншигчид.

Лавлагаа ном зүйн ажлын хүрээнд:

Уншлагын танхим болон цахимаар 62 уншигчид 120 лавлагаа өгч үйлчилсэн.

“Ном унших арга” “Номын тэмдэглэл хэрхэн хөтлөх вэ?” сэдэвт брошурыг бэлтгэн 65 ширхэгийг уншигч хүүхдүүдэд танилцууллаа.



Ном хэвлэх сурталчлах ажлын хүрээнд:

Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 1 удаа гаргасан. Үүнд: “Монгол цэргийн өдөр” Орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 103 жилийн ойд зориулан.



Дээд шатны удидлагаас болон ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд.

1. Байгууллагын ойр орчмын 50 метр газрын цэвэрлэгээг 2 удаа хийж. Сүмбэр сумаас хуваарилан өгсөн газрын цэвэрлэгээг 14 хоног тутам цэвэрлэж Хоггүй сүмбэр пэйж хуудсанд байршуулан мэдээллэж байна. Мөн гаднах орчны цасыг цэвэрлэж халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна.







2. 2024 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгууллаа.



3. Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас зохион байгуулагдах ICT EXPO арга хэмжээнд 7 албан хаагч хамрагдаж оролцсон.



4. Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын уриалга малчиддаа туслах “Бид хамтдаа аян”-д нэгдэж Соёл урлагийн газар, аймгийн Нийтийн Номын сан, “Боржигин өв” музейн албан хаагчид Сүмбэр сумын 5-р багийн малчин Г.Майнбаярынд очиж өвөлжөөний цасыг цэвэрлэн, хаваржаа хүрэх зам гаргаж, шар усны үерээс сэргийлэх шуудуу татаж, малын сэгийг зөөвөрлөж ажиллалаа. Мөн мал ахуйд нь дэмжлэг болгож 2 шуудай хүчит тэжээлийн дэмжлэг үзүүлээ.



5. Оюуны өмч, зохиогчийн эрх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх цахим сургалтад 9 албан хаагч хамрагдсан.
6. Говьсүмбэр аймгийн БОАЖГазраас уриалсан "Сэтгэл шингэсэн нэг боодол өвс" аянд нэгдэж Чойрын богд уулан дах аргальд 10 боодол өвс тавьж өгсөн.



Төрийн албан хаагчийн сургалтын төлөвлөгөөний дагуу:

Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн, Хамгааллын газраас зохион байгуулсан байгууллагын эцэг эхийн зөвлөлийн чадавхижуулах сургалтанд 2 албан хаагч оролцсон.



Насан туршийн боловсролын төвөөс “Угийн бичиг” хөтлөх анхан шатны сургалтад 4 албан хаагч хамрагдсан.



DIGITAL FIRSD D1 арга хэмжээний сургалтанд 2 албан хаагч хамрагдсан.



Тайлан бичсэн: Программист, хүний нөөц

С.Анхбаяр

БАТЛАВ

ЗАХИРЛЫГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ХИШИГДОРЖ

2024 оны.... сарын ... өдөр

НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ 04-Р САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх.

Ажлын чиглэл	№	Хийх ажлын жагсаалт	Хугацаа	Хариуцах мэргэжилтэн хамтран ажиллах байгууллага
Нэгдүгээр хэсэг: Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх				
Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх.	1.1.1	Байгууллагын ажилчдад монгол бичгийн даалгавар өгөх, уншуулах	03-20 04-20	Сан хөмрөгч, хүний нөөц
	1.1.2	Байгууллагын мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах, цахим сайт ажиллуулах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах	03-20 04-20	Нягтлан бодогч Прогхаммист
	1.1.3	Мэдээ, тайланг журмын дагуу гаргаж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх	Тухай бүр	Сан хөмрөгч, хүний нөөцийн ажилтан
	1.1.4	Бусад хууль, тогтоомж шийдвэрүүдийг цаг тухай бүрт нь хэрэгжүүлэн тайлагнах	Тухай бүр	Сан хөмрөгч, хүний нөөцийн ажилтан
Хоёрдугаар хэсэг: Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх				
	2.1.1	Фондын урагдаж гэмтсэн ном хэвлэлийг стандартын түвшинд сэргээн засварлах	Тухай бүр	Номын санч мэдээллийн ажилтан
	2.1.2	Номын сангийн электрон каталогт тогтмол редакц хийж цаасан каталогийг баяжуулах	03-20 04-20	Арга зүйч
	2.1.3	Ном хэвлэлийг стандартын дагуу цэвэрлэх, ариутгах,	03-20 04-20	Номын санч мэдээллийн ажилтан

	2.1.4	Нийтийн уншлагын танхимын болон Сан хөмрөгийн чийгшлийг сайжруулах	03-20 04-20	Номын санч мэдээллийн ажилтан
	2.1.5	Уншлагын танхим, гэр, зөөврөөр иргэд, уншигчдад үйлчлэх	03-20 04-20	Номын санч мэдээллийн ажилтан
Гуравдугаар хэсэг: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт арга хэмжээ				
Иргэдэд ном хэвлэл мэдээллээр үйлчлэх.	3.1.1	Ном уншлагын сарын аян зохион байгуулах	03-01 05-01	Арга зүйч, номын санч мэдээллийн ажилтан
	3.1.2	“Боржигидай яргуй” яруу найргийн наадам зохион байгуулах	03-23	Комиссын гишүүд
	3.1.3	Байгууллагын цахим сайт ажиллуулах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах	03-20 04-20	Программист
	3.1.4	Байгууллагын хамт олны туршлага судлах ажлыг зохион байгуулах	04-04 04-05	Дарга, нягтлан бодогч, сан хөмрөгч хүний нөөц
	3.1.5	Шинэ номын мэдээ бэлтгэж гаргах	сардаа	Арга зүйч
	3.1.6	Уншигчдын хэрэгцээт фондод байхгүй ном хэвлэлийг татгалзлын дэвтэрт бүртгэж хийх жагсаалт гаргах	03-20 04-20	Номын санч мэдээллийн ажилтан
	3.1.7	СГЗ,яруу найрагч Р.Батжаргалын “Гүйдэг Гэндэн” номын жимээр хүүхдийн танин мэдэхүйн аялал зохион байгуулах	4-р сард	Арга зүйч, Номын санч мэдээллийн ажилтан
	3.1.8	Номын сангийн тавилга хийлгэх	4-р сард	Захирал, Арга зүйч
	3.1.9	Иргэд уншигчдыг лавлагаа мэдээллээр хангах	03-20 04-20	Арга зүйч

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
 САН ХӨМРӨГЧ, ХҮНИЙ НӨӨЦ С.АНХБАЯР

